



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/589

Есөнбулаг

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны хэрэглэгдэхүүний зардалд дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 38 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн 3.5.1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны хэрэглэгдэхүүний зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР